СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Шаамар сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: СЭА-2025/118/НА-СТА-ТШЗ**


| | |
|---|---|
| Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn<br>Сүхбаатар сум<br>2025 он | Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа<br>Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn<br>Аудитын менежер: Б.Батмөнх<br>Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn<br>Аудитыг гүйцэтгэсэн: "Пийк Ом Аудит"<br>Утас: 99052418 Цахим хаяг: cheegii9989@gmail.com |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын дүгнэлт 3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл 5-9
3. Санхүүгийн тайлангийн тодруулга 10-14
   3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа 10
   3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин 10-11
   3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал 11
   3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт 11-12
   3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв 12-14
4. Аудитын тайлан 15-18
   4.1 Ерөнхий зүйл 15
   4.2 Материаллаг байдал 15
   4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт 15-16
   4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал 16
   4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт 16-17
   4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал 17-18
5. Аудитын илрүүлэлт 18
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл 18-19

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| БШУС | Боловсрол, шинжлэх ухааны сайд |
| БШУЯ | Боловсрол, шинжлэх ухааны яам |
| ЕБС | Ерөнхий боловсролын сургууль |
| НДШ | Нийгмийн даатгалын шитгэл |
| ХХК | Хязгаарлагдмал хариуцлагатай компани |
| ТБОНӨХБАҮХА | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах |

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № СЭА-2025/118/НА-СТА-ТШЗ

танай ______________-ны № ________________-т

ШААМАР СУМЫН СУМЫН
1 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Ц.БОЛОРМАА ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Шаамар сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тус цэцэрлэг нь Боловсролын ерөнхий газрын даргын 2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/355 дугаар тушаалаар сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр 3 дугаар түвшинд үнэлэгдэж урамшууллалд 8,87.0 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.



432502115

**Аудитын гол асуудал**

Дээд шатны төсвийн захирагчаас тус цэцэрлэгийн тайлант оны төсвийн төлөвлөлт, хуваарилалтыг тухайн сарын гүйцэтгэлд үндэслэн тайлант онд нийт 7 удаа өөрчилж, зохицуулалт хийж байгаа буюу бодит гүйцэтгэлтэй уялдуулан өөрчилж байгаа нь төсвийн төлөвлөлтийг тооцоо, судалгаанд үндэслэн бодитоор төлөвлөдөггүй болохыг харуулж байна.

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

**Бусад асуудлын хэсэг**

Тус байгууллага нь тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 49 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 94.1 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх болович үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.ЭНХТУЯА

СЭА-2025/118/НА-СТА-ТШЗ

# АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*/төгрөгөөр/*

| Данс | Балансын зүйл | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| I | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 118,062,893.52 | 77,317,642.87 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 77,104,595.58 | 38,760,022.15 |
| 311 | Кассанд байгаа бэлэн мөнгө | | |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 77,104,595.58 | 38,760,022.15 |
| 3121 | Төгрөг | 77,104,595.58 | 38,760,022.15 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 77,104,595.58 | 38,760,022.15 |
| 33 | АВЛАГА | 54,423.72 | |
| 331 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 54,423.72 | |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 40,903,874.22 | 38,557,620.72 |
| 354 | Хангамжийн материал | 40,903,874.22 | 38,557,620.72 |
| 3541 | Бичиг хэргийн материал | 155,000.00 | 155,000.00 |
| 3542 | Аж ахуйн материал | 24,996,914.22 | 23,537,260.72 |
| 3546 | Хүнсний материал | 1,954,150.00 | 1,392,325.00 |
| 3547 | Бусад хангамжийн материал | 13,797,810.00 | 13,473,035.00 |
| II | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 289,593,245.44 | 290,778,560.79 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 289,593,245.44 | 290,778,560.79 |
| 392 | Биет хөрөнгө | 279,089,245.44 | 280,274,560.79 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 273,357,400.00 | 273,357,400.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -35,968,078.80 | -43,161,694.56 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 51,740,200.00 | 54,438,100.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -41,650,476.84 | -39,742,876.38 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 18,094,276.28 | 19,817,306.28 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -9,264,148.07 | -7,989,696.28 |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 6,477,900.00 | 6,477,900.00 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 38,086,893.00 | 42,986,893.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -22,119,971.13 | -26,200,622.27 |
| 39217 | Ном | 335,251.00 | 291,851.00 |
| 393 | Биет бус хөрөнгө | 10,504,000.00 | 10,504,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 10,504,000.00 | 10,504,000.00 |
| III | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 407,656,138.96 | 368,096,203.66 |
| IV | НИЙТ ӨР ТӨЛБӨР | | 1,399,810.22 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | | 1,399,810.22 |
| 413 | Өглөг | | 1,399,810.22 |
| 4131 | Ажилчидтай холбогдсон өглөг | | 1,399,810.22 |
| V | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 407,656,138.96 | 366,696,393.44 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 407,656,138.96 | 366,696,393.44 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 72,194,770.87 | 72,194,770.87 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 59,143,744.52 | 18,183,999.00 |
| 5121 | Өмнөх үеийн үр дүн | 59,143,744.52 | 59,143,744.52 |

| | | | |
|---|---|---|---|
| 5122 | Тайлант үеийн үр дүн | | -40,959,745.52 |
| 513 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 276,317,623.57 | 276,317,623.57 |
| VI | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 407,656,138.96 | 368,096,203.66 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*/төгрөгөөр/*

| Данс | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 480,582,914.31 | 630,776,683.59 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 1,995,422.72 | 12,584,000.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 1,995,422.72 | 12,584,000.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 1,000,000.00 | |
| 120009 | Бусад орлого | | 35,000.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | | 12,185,000.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 995,422.72 | 364,000.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 478,587,491.59 | 618,192,683.59 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 435,365,800.00 | 574,718,900.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 435,365,800.00 | 574,718,900.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 43,221,691.59 | 43,473,783.59 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 43,221,691.59 | 43,473,783.59 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 457,775,103.50 | 670,372,845.26 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 457,775,103.50 | 670,372,845.26 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 457,775,103.50 | 663,537,645.26 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 309,560,134.42 | 489,120,265.33 |
| 210101 | Үндсэн цалин | 255,320,712.66 | 332,500,549.85 |
| 210102 | Нэмэгдэл | 46,090,105.46 | 146,988,165.48 |
| 210104 | Урамшуулал | 8,149,316.30 | 9,631,550.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 39,599,015.09 | 61,684,617.04 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 27,386,782.72 | 43,389,185.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,224,114.88 | 5,071,385.49 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,504,092.18 | 2,434,527.25 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 652,971.09 | 2,141,169.93 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,831,054.22 | 8,648,349.37 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 39,751,691.59 | 38,973,783.59 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,379,545.23 | 6,876,800.79 |
| 210302 | Түлш, халаалт | 32,096,046.36 | 32,096,982.80 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,276,100.00 | |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 1,973,600.00 | 3,786,228.50 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,973,600.00 | 849,800.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | | 260,700.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | 362,500.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210408 | Бараа материал акталсны зардал | | 2,313,228.50 |
| 2105 | Нормативт зардал | 33,125,284.00 | 39,174,250.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 27,110.00 | 183,775.00 |
| 210502 | Хоол, хүнс | 33,098,174.00 | 38,990,475.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 3,470,000.00 | 4,500,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,470,000.00 | 4,500,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 360,000.00 | 1,621,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | | 331,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 360,000.00 | 1,290,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 29,935,378.40 | 24,677,500.80 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,208,500.00 | 5,464,200.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 22,726,878.40 | 19,213,300.80 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | | 6,835,200.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | | 6,835,200.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 6,835,200.00 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 22,807,810.81 | -39,596,161.67 |
| 145 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН | | |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | | 1,363,583.85 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | | 1,363,583.85 |
| IV | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | | -1,363,583.85 |
| V | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 22,807,810.81 | -40,959,745.52 |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*/төгрөгөөр/*

| Данс | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 479,587,491.59 | 618,227,683.59 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 1,000,000.00 | 35,000.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 1,000,000.00 | 35,000.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 1,000,000.00 | |
| 120009 | Бусад орлого | | 35,000.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 478,587,491.59 | 618,192,683.59 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 435,365,800.00 | 574,718,900.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 435,365,800.00 | 574,718,900.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | | |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 43,221,691.59 | 43,473,783.59 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 43,221,691.59 | 43,473,783.59 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 436,693,639.58 | 646,995,057.02 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 436,693,639.58 | 646,995,057.02 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 436,693,639.58 | 640,159,857.02 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 311,213,799.90 | 488,113,348.43 |

| | | | |
|---|---|---|---|
| 210101 | Үндсэн цалин | 234,798,184.06 | 316,058,384.75 |
| 210102 | Нэмэгдэл | 66,566,430.25 | 162,129,113.68 |
| 210104 | Урамшуулал | 9,849,185.59 | 9,925,850.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 39,355,380.09 | 61,237,300.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 27,264,308.17 | 41,641,400.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,207,814.90 | 4,899,000.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,487,291.98 | 2,449,500.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 570,250.62 | 2,449,500.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,825,714.42 | 9,797,900.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 39,751,691.59 | 38,973,783.59 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,379,545.23 | 6,876,800.79 |
| 210302 | Түлш, халаалт | 32,096,046.36 | 32,096,982.80 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,276,100.00 | |
| 2105 | Нормативт зардал | 33,398,258.00 | 38,064,650.00 |
| 210502 | Хоол, хүнс | 33,398,258.00 | 38,064,650.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 3,470,000.00 | 4,500,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,470,000.00 | 4,500,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 360,000.00 | 1,621,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 360,000.00 | 1,621,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 9,144,510.00 | 7,649,775.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,535,910.00 | 3,560,175.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,608,600.00 | 4,089,600.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | | 6,835,200.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | | 6,835,200.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 6,835,200.00 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 42,893,852.01 | -28,767,373.43 |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | | 9,577,200.00 |
| | Дотоод эх үүсвэрээр | | 9,577,200.00 |
| | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | | 9,577,200.00 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | | (9,577,200.00) |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 42,893,852.01 | -38,344,573.43 |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 77,104,595.58 |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 38,760,022.15 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*/төгрөгөөр/*

| Д/Д | Үзүүлэлт | Засгийн газрын сан | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | ЗГ-н хувь оролцооны дүн |
|---|---|---|---|---|---|
| 10 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 72,194,770.87 | 276,317,623.57 | 59,143,744.52 | 407,656,138.96 |
| 11 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | |
| 12 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | | | | |
| 13 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | | | |
| 14 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | | | | |
| 15 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгүй олз, гарз | | | | |
| 17 | Тайлант үеийн үр дүн | | | -40,959,745.52 | -40,959,745.52 |
| 19 | 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 72,194,770.87 | 276,317,623.57 | 18,183,999.00 | 366,696,393.44 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*/төгрөгөөр/*

| Д/Д | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 702,152,700.00 | 656,559,757.02 | 45,592,942.98 | 93.5 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 702,152,700.00 | 666,136,957.02 | 36,015,742.98 | 94.9 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 695,311,100.00 | 659,301,757.02 | 36,009,342.98 | 94.8 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 523,356,700.00 | 488,113,348.43 | 35,243,351.57 | 93.3 |
| 210101 | Үндсэн цалин | 339,595,400.00 | 316,058,384.75 | 23,537,015.25 | 93.1 |
| 210102 | Нэмэгдэл | 173,328,800.00 | 162,129,113.68 | 11,199,686.32 | 93.5 |
| 210104 | Урамшуулал | 10,432,500.00 | 9,925,850.00 | 506,650.00 | 95.1 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 62,582,200.00 | 61,237,300.00 | 1,344,900.00 | 97.9 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 42,556,600.00 | 41,641,400.00 | 915,200.00 | 97.9 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,005,900.00 | 4,899,000.00 | 106,900.00 | 97.9 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,503,300.00 | 2,449,500.00 | 53,800.00 | 97.9 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,503,300.00 | 2,449,500.00 | 53,800.00 | 97.9 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 10,013,100.00 | 9,797,900.00 | 215,200.00 | 97.9 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 45,869,600.00 | 38,973,783.59 | 6,895,816.41 | 85.0 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,353,100.00 | 6,876,800.79 | 476,299.21 | 93.5 |
| 210302 | Түлш, халаалт | 38,516,500.00 | 32,096,982.80 | 6,419,517.20 | 83.3 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | | | | |
| 2105 | Нормативт зардал | 39,085,700.00 | 38,064,650.00 | 1,021,050.00 | 97.4 |
| 210502 | Хоол, хүнс | 39,085,700.00 | 38,064,650.00 | 1,021,050.00 | 97.4 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 4,500,000.00 | 4,500,000.00 | | 100.0 |
| 210604 | Урсгал засвар | 4,500,000.00 | 4,500,000.00 | | 100.0 |
| 2107 | Томилолт, зочны зардал | | | | |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,621,000.00 | 1,621,000.00 | | 100.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,621,000.00 | 1,621,000.00 | | 100.0 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 18,295,900.00 | 26,791,675.00 | -8,495,775.00 | 146.4 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 14,206,300.00 | 20,559,675.00 | -6,353,375.00 | 144.7 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,089,600.00 | 6,232,000.00 | -2,142,400.00 | 152.4 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 6,841,600.00 | 6,835,200.00 | 6,400.00 | 99.9 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 6,841,600.00 | 6,835,200.00 | 6,400.00 | 99.9 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 6,841,600.00 | 6,835,200.00 | 6,400.00 | 99.9 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | | -9,577,200.00 | 9,577,200.00 | |
| | Дотоод эх үүсвэрээр | | -9,577,200.00 | 9,577,200.00 | |
| 223001 | Бусад хөрөнгө | | -9,577,200.00 | 9,577,200.00 | |
| 1 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 702,152,700.00 | 618,227,683.59 | 83,925,016.41 | 88.1 |
| 131 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 651,783,100.00 | 574,718,900.00 | 77,064,200.00 | 88.2 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 651,783,100.00 | 574,718,900.00 | 77,064,200.00 | 88.2 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | | | | |
| 132 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 50,369,600.00 | 43,473,783.59 | 6,895,816.41 | 86.3 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 50,369,600.00 | 43,473,783.59 | 6,895,816.41 | 86.3 |
| 133 | ТӨСВИЙН ЗАХИРАГЧДААС | | | | |
| 134 | НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | | | | |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | | | | |
| 124 | БУСАД ЭХ ҮҮСВЭР | | | | |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 77,104,595.58 | -77,104,595.58 | |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 38,760,022.15 | -38,760,022.15 | |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Шаамар сумын 1 дүгээр цэцэрлэг нь "*Багшийн гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнд суурилан цэцэрлэгийн менежментийг сайжруулж, сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээг хүүхэд бүрт тэгш хүртээмжтэй хүргэн сурлагын чанарт ахиц гаргах зорилгыг хамтын оролцоотойгоор хэрэгжүүлнэ*" гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Үйл ажиллагааны зорилтуудаа дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Боловсролын ерөнхий хууль, сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийг суралцагч, эцэг эх, асран хамгаалалгч, багш, ажилтан, иргэд, олон нийтэд сурталчлан таниулах, тэдний оролцоог хэрэгжүүлэх;
- Мэргэжлийн хөгжлийн бүлгээр хамтран ажиллах;
- Багш ажилчдын мэргэжлийн ёс зүйг өндөрт өргөн багшлахуй ба суралцахуйн үр дүнд ахиц гаргах;
- Тогтвортой хөгжлийн хүрээнд мөнгөн гэрэгэ авах;
- Хүүхдэд байгалийг хайрлах, арчлах, хамгаалах төлөвшил суулгах;
- Хүүхдэд ээлтэй эрүүл аюулгүй орчин бүрдүүлэх

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой;*
- *Засгийн газрын 2024 оны 01 сарын 25-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор "Хувьсах зардал болон гүйцэтгэл,үр дүнд суурилан санхүүжүүлэх журам" ;*
- *Засгийн газрын 2024 оны 01 сарын 17-ны өдрийн 25 дугаар тогтоолоор"Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл,чанар,үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам";*
- *Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн 128 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон;*
- *Засгийн газрын 2024 оны 05 сарын 29 өдрийн 237 дугаар тогтоолоор цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын хэмжээг шинэчлэн тогтоосон;*
- *Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28–ний өдрийн 84 дүгээр тогтоолоор хөдөө орон нутгийн нэмэгдэл шинэчлэгдсэн гэх мэт.*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд Боловсролын ерөнхий газрын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Шаамар сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь БШУС-ын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, шинжлэх ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй өөрөөр хэлбэл боловсролын салбарын онцлогт тохирохгүй байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сэлэнгэ аймгийн Шаамар сумын 1 дүгээр цэцэрлэг нь 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 39,559.9 мянган төгрөгөөр буюу 10.7 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

*/мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| **Б** | **1** | **2** | **3=2-1** |
| Мөнгөн хөрөнгө | 77,104.6 | 38,760.0 | (38,344.6) |
| Авлага | 54.4 | - | (54.4) |
| Бараа материал | 40,903.9 | 38,557.6 | (2,346.3) |
| Үндсэн хөрөнгө | 289,593.2 | 290,778.6 | 1,185.3 |
| **Нийт хөрөнгө** | **407,656.1** | **368,096.2** | **(39,559.9)** |
| Өр төлбөр | - | 1,399.8 | 1,399.8 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 407,656.1 | 366,696.4 | (40,959.7) |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **407,656.1** | **368,096.2** | **(39,559.9)** |

Дээрх хүснэгтээс үзэхэд дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 38,760.0 мянган төгрөг болж 38,344.6 мянган төгрөгөөр буурсан нь хөрөнгийн зарцуулалттай холбоотойгоор,

- Бараа материалын дансны үлдэгдэл 38,557.6 мянган төгрөг болж 2,346.3 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 44,489.5 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, иргэнээс 364.0 мянган төгрөгийн мах хандиваар авсан, цаашид ашиглах боломжгүй 2,313.2 мянган төгрөгийн хөрөнгийг сумын ИТХ-ын хурлын 129 дүгээр тогтоолын дагуу акталж данс бүртгэлээс хасаж, үйл ажиллагаанд 44,886.5 мянган төгрөгийн бараа материал зарцуулснаас;
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл */анхны өртгөөр/* 407,873.4 мянган төгрөг болж 9,277.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр 9,577.2 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авч, сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2,780.0 мянган төгрөгийн хяналтын камер, ААН иргэдээс 9,405.0 мянган төгрөгийн тоглоом, тоног төхөөрөмж зэрэг нийт 12,185.0 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй орлогоор бүртгэсэн, өртгөө бүрэн нөхсөн, цаашид ашиглах боломжгүй 12,484.7 мянган төгрөгийн хөрөнгийг сумын ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 129 дүгээр тогтоолоор акталж данс бүртгэлээс хассан нь нөлөөлжээ. Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл 117,094.9 мянган төгрөг бөгөөд 290,778.5 мянган төгрөгийн үлдэгдэл өртөгтэй байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд улсын төсвөөс 458,011.8 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 50,369.6 мянган төгрөг, нийт 508,381.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, зарцуулахаар дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг хэвээр баталсан байна. .

Тайланд онд төсөвт 7 удаа зохицуулалт хийгдэж улсын төсвөөс 651,783.1 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 50,369.6 мянган төгрөгийн, нийт **702,152.7** мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлэхээр эцэслэн баталсан байна. Үүнд:

- Цалин хөлс, НДШ-ийн зардлыг 125,025.7 мянган төгрөгөөр,
- Тогтмол зардлыг 45,869.6 мянган төгрөгөөр,
- Хүүхдийн хоолны зардлыг 9,866.7 мянган төгрөгөөр,
- Мэдээлэл технологийн үйлчилгээний зардлыг 1,021.9 мянган төгрөгөөр,
- Бараа үйлчилгээний бусад зардлыг 6,849.3 мянган төгрөгөөр,
- Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлыг 195.2 мянган төгрөгөөр;
- Урсгал шилжүүлгийн зардлыг 5,841.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлж
- Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлыг 898.7 мянган төгрөгөөр бууруулсан гэх мэт

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр нийт **702,152.7** мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж урсгал үйл ажиллагаанд 656,559.8 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 656,559.8 мянган төгрөг буюу хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлыг 45,592.9 мянган төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

*/мянган төгрөгөөр/*

| Д/д | Хөтөлбөр | Д/д | Арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 71801 Сургуулийн өмнөх боловсрол | 1 | 81605-Эрүүл мэндийг дэмжих | 898.8 | 898.8 | 0.0 | 100.0 |
| | | 2 | 81807-Цэцэрлэгийн хүүхдийн хоол | 39,085.7 | 38,064.7 | 1,021.1 | 97.4 |
| | | 3 | 81816-Хүүхдэд ээлтэй сургалтын орчин | 1,964.8 | 1,964.8 | - | 100.0 |
| | | 4 | 81823-Боловсролын байгууллагын багш | 977.0 | 976.1 | 0.9 | 99.9 |
| | | 5 | 81834-Боловсролын стандарт сургалт | 592,585.8 | 554,917.4 | 37,668.4 | 93.6 |
| | | 6 | 81835-Сургалтын хэвийн үйл ажиллагаа | 14,613.6 | 14,607.2 | 6.4 | 100.0 |
| | | 7 | 83602- ЗГ болон засаг даргын нөөц хөрөнгөнөөс хуваарилсан | 1,000.0 | 1,000.0 | - | 100.0 |
| | | 8 | 80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал | 50,369.6 | 43,473.8 | 6,895.8 | 86.3 |
| | | 9 | 80233-Хүүхэд хамгаалал | 657.4 | 657.0 | 0.4 | 99.9 |
| **Нийт** | | | | **702,152.7** | **656,559.8** | **45,592.9** | **93.5** |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны *“Чиглэл хүргүүлэх тухай”* албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хаасан байна.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд дараах худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАУХА тухай хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулж, зохион байгуулсан байна. Үүнд:

*/мянган төгрөгөөр /*

| № | Тухайн жилд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо, хэмжээ, хүчин чадал | Батлагдсан төсөв | Гэрээний дүн | Тендер шалгаруулалтын арга |
|---|---|---|---|---|
| 1 | Хүүхдийн хоол | 39,780.0 | 39,780.0 | НТШ |
| | **Нийт дүн** | **39,780.0** | **39,780.0** | |

Бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендер шалгаруулалтад гүйцэтгэгчээр шалгарсан "Сэлэнгэ Буманбуудай ХХК"-тай 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдөр гэрээ байгуулан, худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Шаамар сумын 1 дүгээр цэцэрлэгийн *Iцаашид Шаамар сумын 1 дүгээр цэцэрлэг гэх/* 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн эцэг эхчүүдээс хүүхдийн сургалт, эрүүл ахуйн хэрэгцээнд үнэ төлбөргүй өгсөн хөрөнгийг орлогоор бүртгэж зарцуулалтад хяналт тавих зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу "Пийк Ом Аудит" ХХК-ийн аудитор Б.Наранчимэг гүйцэтгэж, хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Шаамар сумын 1 дүгээр цэцэрлэг нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн А/04 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 457,775.1 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 4,577.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Шаамар сумын 1 дүгээр цэцэрлэг нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Үйл ажиллагаатай холбоотой сурталчилгаа, баяр ёслолын арга хэмжээг зохион байгуулаагүй, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдаж аваагүй,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд тус сургууль нь шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 20 төрлийн 171 мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хамаарах алдаа, зөрчил илрээгүй.

## 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

### 4.5.1 Завсрын аудитын талаар

“Пийк Ом аудит “ХХК нь 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 916 дугаар албан бичгээр “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” захидлыг тус байгууллагад хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар авлага барагдуулах 1 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

*/мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Зөвлөмж | 1 | 54.1 | 1 | 54.1 | 100.0 |
| **Нийт дүн** | **1** | **54.1** | **1** | **54.1** | **100.0** |

## 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

# 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой дараах 41,640.4 мянган төгрөгийн алдааг залрууллаа.Үүнд:

- Худалдан авсан 9,577.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг мөнгөн гүйлгээний тайланд бараа материалын зардлаар бүртгэж тусгасан;
- Тайлант жилийн үр дүнг буруу илэрхийлсэн 32,063.4 мянган төгрөгийн,

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Аудитаар 6,568.9 мянган төгрөгийн зөрчил[1] илэрч 1,399.8 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага, 5,169.1 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй ажиллах 1 зөвлөмж хүргүүллээ.

## 5.1 Албан шаардлага

1.Төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас 1,399.8 мянган төгрөгийн ХХОАТ-ын өглөг үүсгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

дахь "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

**<u>Шийдвэрлэсэн нь:</u>** Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх албан шаардлага хүргүүлэх.

**5.2 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. **Үнэ төлбөргүй хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал**

1.1 Илрүүлэлт: Эцэг эхчүүдээс хүүхдийн сургалт, эрүүл ахуйн хэрэгцээнд үнэ төлбөргүй өгсөн 5,169.1 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна..

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4. Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.1-д *"аж ахуйн бүх ажил, гүйлгээ"*, 14.4.5-д *"бүх орлого"* гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Үнэ төлбөргүй хүлээн авсан орлогыг бүртгэлд бүрэн тусгаж, зарцуулалтад хяналт тавьж ажиллах

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5 дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл:**

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Мөнгөн гүйлгээний тайланд худалдан авсан үндсэн хөрөнгийг бараа материалын зардлаар бүртгэж тусгасан | 1 | 9,577.0 | | | 1 | 9,577.0 | 1 | 9,577.0 | | | | |
| Тайлант жилийн үр дүнг буруу илэрхийлсэн | 1 | 32,063.4 | | | 1 | 32,063.4 | 1 | 32,063.4 | | | | |
| **Нийт** | **2** | 41,640.4 | | | **2** | 41,640.4 | **2** | 41,640.4 | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

*/мянган төгрөгөөр/*

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Эцэг,эхчүүдээс авсан хичээл, ариун цэврийн хэрэглэлийг орлогоор бүртгээгүй | 1 | 5,169.1 | | | | | 1 | 5,169.1 | | | | |
| ХХОАТ өглөг үүсгэсэн | 1 | 1,399.8 | | | 1 | 1,399.8 | | | | | | |
| **Дүн** | **2** | 6,568.9 | | | 1 | 1,399.8 | 1 | 5,169.1 | | | | |

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АЛБАН ШААРДЛАГА**

2025 оны 02 сарын 25 өдөр Дугаар 45/11850385 Сүхбаатар

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Шаамар сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас 1,399.8 мянган төгрөгийн ХХОАТ-ын өглөг үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д *"Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө"*, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан *"Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох"* журмын 4.2.1-д *"Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана. Үүнд: 4.2.1.11: "Хууль тогтоомж, ……зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"* гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийг зохистой удирдаагүйгээс өр төлбөр үүсгэсэн зөрчлийг арилган давтан гаргахгүй ажиллаж, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид холбогдох хууль, тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллаж, биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Сэлэнгэ аймгийн Шаамар сумын 1 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч Ц.Болормаа, нягтлан бодогч Э.Оргил нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.ЭНХТУЯА

АУДИТОР Б.НАРАНЧИМЭГ

432504223

*Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 09 өдрийн А/95 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт*

# АЛБАН ШААРДЛАГА, ТӨЛБӨРИЙН АКТЫН БҮРТГЭЛ, ХЯНАЛТЫН ХУУДАС

## А. Албан шаардлага, төлбөрийн актын төсөл бэлтгэж, баталгаажуулах үеийн бүртгэл, хяналт

1.Ерөнхий мэдээлэл

| | | | |
|---|---|---|---|
| 1.1 Аудитын нэр | Сэлэнгэ аймаг Шаамар сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит | 1.2 Аудитын код | СЭА-2025/118/НА-СТА-ТШЗ |

| | | | |
|---|---|---|---|
| 1.3 Аудит хийсэн үндэслэл | Төрийн аудитын тухай хуулийн 6.3.1, 8.1, Төсвийн тухай хуулийн 8.9.1 | 1.4 Аудитын төрөл | Санхүүгийн тайлангийн аудит |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 1.5 Албан шаардлага / төлбөрийн актын дугаар | 7.5/А1850385 СЭА-2025/118/НА-СТА-ТШЗ | 1.6 Огноо | 2025.02.24 | 1.7 Мөнгөн дүн /төгрөгөөр/ | 1,399,800.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 1.8 Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох үндэслэл | Алдаа зөрчлийн товч утга | Төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас 1,399.8 мянган төгрөгийн ХХОАТ-ын өглөг үүсгэсэн байна. | |
| | Алдаа зөрчлийн ангилал | Хууль, тогтоомж зөрчсөн | |
| | Журмын заалт (4.2-оос аль тохирохыг оруулах) | 4.2.1.11: "Хууль тогтоомж, ……зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал | |
| | Зөрчсөн эрх зүйн актын | Нэр | Төсвийн тухай хууль |
| | | Заалт | 6.4.8 |
| | Үндэслэл болгосон эрх зүйн актын | Нэр | Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаал |
| | | Заалт | 4.2.1.9, 4.2.1.11 |

| | | | |
|---|---|---|---|
| 1.9 Төлбөр барагдуулах хэлбэр / төгрөгөөр/ | Улсын төсвийн дансанд | | 1.10 Төлбөр, зөрчил барагдуулах огноо |
| | Орон нутгийн төсвийн дансанд | | |
| | Тухайн байгууллагын дансанд | | |
| | | | |

2. Үндэслэл болгосон гол нотлох баримтын талаарх мэдээлэл

| № | Нотлох баримтын нэр төрөл | Дугаар | Огноо | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1 | Бараа материалын тайлан | | 2024 он | |
| 2 | Харилцахын баримт | | 2024 он | |

3. Аудитын баг болон хариуцагчийн талаарх мэдээлэл

| № | Аудитын багийн | | Хариуцагч | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Овог нэр | Албан тушаал | Байгууллагын нэр | Албан тушаал | Овог нэр | Холбоо барих хаяг, утас |
| 1 | Б.Наранчимэг | Аудитор | Шаамар 1 дүгээр цэцэрлэг | Эрхлэгч | Ц.Болормаа | 99964981 |
| | | | | Нягтлан бодогч | Э.Оргил | 99065397 |

4. Албан шаардлага, төлбөрийн акт бэлтгэх үеийн чанарын хяналт

4.1 Чанарын хяналт хийсэн тэмдэглэл

| № | Албан тушаалтан | Огноо | Чанарын хяналтаар өгсөн санал зөвлөмж | Гарын үсэг |
|---|---|---|---|---|
| 1 | Тэргүүлэх аудитор | II/25 | – | [signature] |
| 2 | Аудитын менежер | II/25 | – | [signature] |

4.2 Албан шаардлага, төлбөрийн актыг хэвлэмэл хуудсанд хэвлэх зөвшөөрөл

| № | Албан тушаал | Овог нэр | Огноо | Гарын үсэг |
|---|---|---|---|---|

| | | | | |
|---|---|---|---|---|
| 1 | Тэргүүлэх аудитор | Ч.Энхтуяа | II/25 | |
| 2 | | | | |

5. Албан шаардлага, төлбөрийн актыг баталгаажуулж, хүргүүлэх үеийн баримтжуулалт

| № | Үзүүлэлт | | | Мэдээлэл оруулах хэсэг | Гарын үсэг |
|---|---|---|---|---|---|
| 1 | Албан шаардлага, төлбөрийн актыг баталгаажуулсан тушаалын | | Огноо | | |
| | | | Дугаар | | |
| 2 | Албан шаардлага, төлбөрийн актыг хүргүүлсэн албан бичгийн | | Огноо | | |
| | | | Дугаар | | |
| 3 | Албан шаардлага, төлбөрийн актыг хүлээлгэн өгсөн | Огноо | | 2025.02.24 | |
| | | Ажилтны | Овог нэр | Б.Наранчимэг | |
| | | | Албан тушаал | Аудитор | |
| 4 | Албан шаардлага, төлбөрийн актыг хүлээн авсан | Байгууллагын нэр | | Шаамар 1 дүгээр цэцэрлэг | |
| | | Ажилтны | Овог нэр | Э.Оргил | |
| | | | Албан тушаал | Нягтлан бодогч | |
| 5 | Албан шаардлага, төлбөрийн актын хэрэгжилтийг хариуцах | Газрын нэр | | Пийк Ом Аудит ХХК | |
| | | Ажилтны | Овог нэр | Б.Наранчимэг | |
| | | | Албан тушаал | Аудитор | |
| 6 | Тооцоолсон зөвшөөрүүлсэн үр өгөөж | Санхүүгийн | Тоо | | |
| | | | Дүн | | |
| | | Санхүүгийн бус үр өгөөжийн тоо | | | |